



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 1/303

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн байгууллагуудын засвар, тоног төхөөрөмж /Өвөрхангай/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Г.Баясгалан -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвсүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын бараа, зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Ц.Навчаа -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн


Г.Даваатогтох -Хувийн хэвшлийн төлөөлөл

Б.Одсүрэн -Мерси кор ОУБ-ын Өвөрхангай аймаг дахь Салбарын Зохицуулагч (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Г.Баясгалан)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100659